



ҮАГазрын харъяа Баян-Өлгий аймаг дахь Аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон
нэгтгэсэн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/5/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.altai.bo.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 89838414 Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22

1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах



АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.АСЕТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 70422954, 70422930
E-mail: bayanulgi@audit.gov.mn

№ 75-БТН-2016/107-ТЗ
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу аймгийн аймгийн Аудитын газраас аудит хийв.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Sanal dugnelt...doc

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Sanal dugneft....doc

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Алтай сумын Засаг дарга А.Асет танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох холбоотой зөвлөмж өгөдөөгүй байна.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2, 8.9.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Алтай сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Алтай сумын ТТЗ-ийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.13-наас 2017.03.21-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.21-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аймгийн Аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Алтай сумын ТТЗ-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017.03.07-нд төрийн аудитын байгууллагад 2017.03.03-ны өдрийн №75 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Алтай сумын ТТЗ *"Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнхээ санхүүгийн байдал, хүн амын орлого, хөдөлмөрийн нөөц, газрын төлөв байдлын удирдлага, төлөвлөлтийг хангахад шаардагдах тайлан тэнцэл гаргах"*

"харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Алтай сумын ТТЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Алтай сумын ТТЗ-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Алтай сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Алтай сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Алтай сумын ТТЗ-ийн бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 17 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 11 асуудал эрсдэл өндөр, 0 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 33 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 11 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тул нийт хөрөнгийг материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтээр сонгох нь тохиромжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Алтай сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгө 4490,7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 44,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дотоод хяналт хэвийн гэж үзсэнтэй холбоотой юм. Чанартай холбоотой асуудал байхгүй.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр эрсдэлтэй асуудалд 9 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 10 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тайлант онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас дутуу олгосон 13,2 сая төгрөгийн санхүүжилтийг

санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүйг байсныг санхүүгийн тайланд залруулга хийж, алдаа зөрчилд тооцов.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал
Үгүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал
Үгүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал
Үгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал
Үгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ
ОНХС, СХСангийн авлага, өглөгийн бүртгэл тооцоо, баталгаажуулалт.

2.11 Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл гүйцэтгэл, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал				/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,670,486.01	59,020,720.79	27,350,234,78
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	34,257.90	-	-34,257,90
31110	Төгрөг	34,257.90		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,636,228.11	59,020,720.79	27,384,492,68
3121	Төгрөг	31,636,228.11	59,020,720.79	27,384,492,68
31211	Төрийн сангийн харилцах	27,605,111.11	58,973,158.79	31,368,047,68
31213	Арилжааны банк дахь харилцах	4,031,117.00	47,562.00	-3,983,555,00

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 59,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,05 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 58,9 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 47,2 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны, 9,9 сая төгрөг нь СХСангийн дансны, 1,8 сая төгрөг нь ОНХСангийн дансны үлдэгдэл байна.

Арилжааны банкинд байгаа 47,6 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн дансны үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	234,883,350.00	238,156,700.00	3,273,350.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		13,184,700.00	13,184,700.00
336	Зээлийн авлага	234,883,350.00	224,972,050.00	-9,911,300.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	234,883,350.00	224,972,050.00	-9,911,300.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	234,883,350.00	224,972,050.00	-9,911,300.00

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 3,3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Аймгийн ОНХСангаас дутуу олгосон санхүүжилтийн хэмжээгээр 13,2 сая төгрөгийн санхүүжилтийн авлага нэмэгдсэн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулсан ба оны эхнээс 9,9 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	145,617,663.16	213,448,500.89	67,830,837.73
351	Түүхий эд материал	55,055,829.30	102,968,037.00	47,912,207.70
354	Хангамжийн материал	90,561,833.86	110,480,463.89	19,918,630.03

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 67,8 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 48,2 хувь нь түүхий эд материал, 51,8 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 21,1 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,557,573,529.59	3,980,314,152.85	422740623.26
391	Газар			0.00
392	Биет хөрөнгө	3,557,407,765.55	3980267666.35	422859900.8
393	Биет бус хөрөнгө	165,764.04	46,486.5	-119,277.54

Үндсэн хөрөнгө оны эхнээс 422,7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 6,5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 659,3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 242,9 сая төгрөгийн элэгдэл тооцож, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 3465.9 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 659.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 62.7 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 523.8 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 15,8 сая төгрөгийн, ЭМТөв 57,0 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 58,3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 74,0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 132,3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

5.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,422,535.00	12,928,468.00	-1,494,067,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,422,535.00	12,928,468.00	-1,494,067,00
413	Өглөг	14,422,535.00	12,928,468.00	-1,494,067,00
4136	Бусад өглөг	14,422,535.00	12,928,468.00	-1,494,067,00
41361	Бараа үйлчилгээний өглөг	14,422,535.00		-14,422,535.00
41362	Байгууллагад төлөх өглөг		12,928,468.00	12,928,468.00

Оны эхэнд ЗДТГазар 7,7 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 4,6 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 0,6 сая төгрөгийн, ЭМТөв 1,5 сая төгрөгийн нийтдээ 14,2 сая төгрөгийн богино хугацаат өглөгийн үлдэгдэлтэй байсныг тайланд онд бүрэн барагдуулж, оны эцэст ОНХСангийн байгууллагуудад төлөх 12,9 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар**6.1 Улсын төсвийн санхүүжилт**

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 1802,0 сая төгрөгийн санхүүжилт, 6,3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагуудад аймгийн төсвөөс 301,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 53,1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 139,1 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Алтай сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 1310,0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 1200,0 мянган төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөөг 8,4 хувиар тасалдуулсан байна.

6.4 Татварын орлого

Алтай сумын ИТХ-аас сумын 2016 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 26,3 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 58,0 хувийг ХАОАТатвараас, 21,7 хувийг бусад татвараас, 20,2 хувийг өмчийн татвараас, 0,09 хувийг хөрөнгийн орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	26,303,000	73,470,798.68	47,167,798.68	279.32%
Татварын орлого	24,247,100	71,759,910.69	45,481,910.69	273.08%
ХАОАТатвар	15,250,000	38,478,430.69	23,228,430.69	169.2%
Өмчийн татвар	5,328,000	2,678,000	2,650,000	50.26%
Бусад татвар	5,700,000	30,603,480	24,903,480.00	536.9%
Татварын бус орлого	0.0	1,710,887.99	1,710,887.90	0,00%
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	25,000	0,00	-25000	

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 73,5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 47,2 сая төгрөгөөр буюу 179,3 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 52,3 хувийг ХАОАТатвараас, 41,6 хувийг бусад татвар, 3,6 хувийг өмчийн татвараас, 2,3 хувийг татварын бус орлогоос бүрдүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 23228,4 мянган төгрөгөөр буюу 252,3 хувиар, бусад татвар 24903,5 мянган төгрөг буюу 536,9 дахин давж, өмчийн татвар 2650,0 мянган төгрөг буюу 50,3 хувиар, хөрөнгийн татвар дүнгээрээ 25,0 мянган төгрөгөөр буюу 100 хувиар тасарчээ. Төлөвлөгөө өгөгдөөгүй агнуурын нөөц ашигласны орлогын татвараас 25,1 сая төгрөгийн, татварын бус орлогын татвараас 1,7 сая төгрөгийн орлогуудыг оруулснаас татварын орлогын төлөвлөгөө давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн орлогын 995 тоот данс оны эхэнд 26,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 73,5 сая төгрөгийн татварын орлого оруулж оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 47,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аймгийн орон нутгийн орлогын 020000901 тоот дансанд 110753,0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Сумын орон нутгийн татварын ерөнхий орлогын 910 тоот дансанд орсон газрын төлбөрийн 38,5 мянган төгрөг, цалин хөлснөөс 14740,5 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 96,6 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 18,9 сая төгрөгийг, Эргэлтийн эмийн санд 5,1 сая төгрөгийн орлого оруулсан байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Алтай сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ 2268,0 сая төгрөгийн төсөв батлагдсаны 1802,0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 354,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 109,8 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 1,3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1802,0 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 354,9 сая төгрөгийн санхүүжилт авч, ОНХСангийн санхүүжилтээр 96,6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, бүгд дүнгээр 2254,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 13,3 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь аймгийн ОНХСангаас 13,2 сая төгрөгийн дутуу олгосон санхүүжилтийн хэмжээгээр болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогын 0,1 сая төгрөг тасарсан хэмжээгээр хэмнэлттэй харагдаж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2268,0	2254,7	0,6%	13,3
1.1	Урсгал зардал	2267,7	2254,5	0,5%	00,0
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	2267,7	2254,5	0,6%	13,2
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	1803,0	1803,0	0,0%	0.0
2.2	Орон нутгийн төсвөөс	354,9	354,9	0,0%	0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	109,8	96,6	12,1%	13,2
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1,3	1,2	-7,7%	0,1

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Сумын ИТХурал	40 529 700	40 529 700	0,00	100%
Сумын ЗДТГазар	314 374 700	314 374 700	0,00	100%
Бүрэн дунд сургууль	1 087 543 300	1 087 543 300	0,00	100%
Эрүүл мэндийн төв	307 963 700	307 963 700	0,00	100%
Хүүхдийн цэцэрлэг	243 909 900	243 909 900	0,00	100%
Соёлын төв	50 553 900	50 553 900	0,00	100%
ОНХ сан	109 784 700	96 600 000	13,184,700	87,9%
Бүгд	2 266 720 400	2 253 535 700	13,184,700	99,4%

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, хангамжийн зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлуудыг 0,5-15,9 сая төгрөгөөр хэмнэж, томилолт, байр ашиглалттай холбоотой зардлуудад гүйлгэн зарцуулсан байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		34257,90	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,268,030,400	2,254,735,702	13,294,698.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,471,645,200	1,471,497,937	147,263.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,008,100	161,537,996	(529,896.00)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,371,200	110,393,120	(21,920.00)
Хангамж, бараа материалын зардал	44,749,900	44,397,200	352,700.00

Нормативт зардал	163,261,700	163,255,900	5,800.00
Эд хогшил, урсгал засварын зардал	9,711,800	8,513,300	1,198,500.00
Томилолт, зочны зардал	6,362,000	6,643,320	(281,320.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,480,900	45,165,902	314,998.00
Бараа үйлчилгээний бусад зардал	142,829,200	126,942,427	15,886,773.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,610,400	112,551,800	58,600.00
Бусад урсгал шилжүүлэг	112,610,400	112,551,800	58,600.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,836,800	(3,836,800.00)
Дотоод эх үүсвэрээр	-	3,836,800	(3,836,800.00)

7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 145,4 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 145,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт

Алтай сумын 5 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр 1803,0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс 1803,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч санхүүжилтийг бүрэн авсан байна.

7.4 Сангийн зарцуулалт

Алтай сумын ОНХСан нь оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд 96,6 сая төгрөгийн санхүүжилт авч, 94,7 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 1,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 0,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 18,9 сая төгрөгийн орлогыг оруулсан ба тайлант онд 8,5 сая төгрөгийн зээл олгож, оны эцэст 11,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 225,0 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа 4,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 5,1 сая төгрөгийн орлого оруулж, 9,05 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,05 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

8. Эзэмшигчийн өмчийн талаар

Алтай сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 520.9 сая төгрөгөөр өсч 4490,7 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 1874,6 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1649,2 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 953,9 сая төгрөг байна.

Алтай сумын сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 522,4 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 953,9 сая төгрөг болж өссөн дүнтэй байна. Алтай сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар дахин үнэлгээний нөөц 1649,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Алтай сумын ТТЗахирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна. Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Алтай сумын ТТЗ-ийн 2016.09.05-ны өдрийн №143 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Алтай сумын ТТЗахирагчийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

